

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны дугаар сарын-ны өдөр

Улаанбаатар хот

МАЛЧНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь уламжлалт өв соёлыг хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх малчны эрх зүйн байдлыг тодорхойлох, малчны хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, нийгмийн хамгаалал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Малчны тухай хууль тогтоомж

2.1.Малчны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, энэ хууль болон малчны үйл ажиллагаатай холбогдсон бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь малчинд төрөөс үзүүлэх дэмжлэг, мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, үйлдвэрлэлийг дэмжих, малчдын эрх ашгийг хамгаалах, малчны хөгжлийг дэмжих, малчны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцаанд хамаарна.

3.2.Мал бүхий хуулийн этгээд энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“мал аж ахуй” гэж байгалийн нөөц, тэдгээрийн нөхөн сэргэх бололцоонд тулгуурлан дасан зохицож, аж төрөх хэв шинж, уламжлал, арга барилд суурилсан мал аж ахуйн био-үйлдвэрлэлийг;

4.1.2.“малчин” гэж жилийн дөрвөн улирлын туршид мал маллаж, малын ашиг шимээр өрхийн үндсэн орлогоо бүрдүүлж, холбогдох хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа 16-аас дээш насны Монгол Улсын иргэнийг;

4.1.3.“туслах малчин” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 71.2-т заасныг;

4.1.4.“малчны бүлэг, хэсэг” /цаашид “малчны бүлэг” гэх/ гэж сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, бэлчээрийн газар нутгийг хамтран ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах хэлбэр, үүргээ харилцан тохиролцож, баталгаажуулсан малчин өрхийн нэгдлийг;

4.1.5.“малчны хоршоо” гэж сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаа, хөдөлмөр, хувь нийлүүлсэн хөрөнгөөр нэгдэж, Хоршооны хуульд нийцүүлэн дүрмээ баталгаажуулж, албан ёсны хуулийн этгээдээр бүртгүүлсэн малчны нэгдлийг;

4.1.6.“мал аж ахуйн зохистой дадал” гэж малчны хотноос хэрэглэгч хүртэлх бэлтгэн нийлүүлэлтийн орчин, нөхцөл, үе шат бүрт болон мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавьж байгаа шаардлага, шалгууртай үйл ажиллагааны дадлыг;

4.1.7.“малчны өрхийн үйлдвэрлэл” гэж өөрийн өмчид суурилж, бэлчээрийн эдэлбэр газрыг ашиглан мал маллаж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс үр шимийг нь хүртэж байгаа гэр бүлийн гишүүдийн үйл ажиллагааг;

4.1.8.“малчны өргөтсөн үйлдвэрлэл” гэж өөрийн өмчид суурилж, бэлчээрийн эдэлбэр газрыг ашиглан мал маллаж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс үр ашиг хүртэж байгаа гэр бүлийн гишүүдийн болон тэдгээртэй гэрээ, хэлцэл байгуулан ажиллаж байгаа туслах малчны хамтын үйл ажиллагааг;

4.1.9.“малчны хоршсон үйлдвэрлэл” гэж бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг аялал жуулчлал, газар тариалан, ойн нөхөрлөлийн чиглэлийн үйл ажиллагаатай хослуулан эрхлэх хэлбэрийг;

4.1.10.“малчны хөгжил” гэж малчин насан туршид боловсрол, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг;

4.1.11.“малчны хариуцлагатай байдал” гэж бэлчээрийн мал аж ахуйн арга ажиллагааг бүс нутгийн онцлог, нийгэм, эдийн засаг, зах зээл, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж, байгаль орчинд ээлтэй, тогтвортой, үйлдвэрлэл эрхлэх төлөв байдлыг;

4.1.12.“хариуцлагатай малчин” гэж бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлд стандартаар тогтоосон зохистой дадлын шаардлага, шалгуурыг хангаж, хэвшүүлсэн байдлыг эрх бүхий байгууллагаар үнэлж, баталгаажуулсан малчны бүлэг, хэсэг, хоршоог;

4.1.13. “хариуцлагатай байдлын баталгаажуулалт” гэж итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаас мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэлт нь зохистой дадлын шаардлага, шалгуурт тохирч байгааг баталж, бичгээр гаргасан шийдвэрийг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МАЛ АЖ АХУЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

5 дугаар зүйл. Малчныг дэмжих төрийн бодлого, зарчим

5.1. Төр нь нүүдлийн аж төрөх хэв шинж, соёл иргэншлийг хадгалан бэлчээрийн нөөцөд суурилсан уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхэлж байгаа малчны талаар төрөөс дараах зарчмыг баримталж, дэмжинэ:

5.1.1. малчин хүний жам ёсны болон хууль ёсны эрх ашиг, хамтын эрхийг хүндэтгэх, хамгаалах, үл ялгаварлах, тэгш байдлыг хангах;

5.1.2. газар болон байгалийн нөөцийг ашиглахад хамааралтай уламжлал, газар эдэлбэрийн зүй ёсны эрхийг олгох, баталгаажуулахад ахиц гаргах;

5.1.3. малчны эрх зүйн чадавхыг бэхжүүлэх;

5.2. Байгаль, экологийн онцлог, байршилтай уялдуулан малчинд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ:

5.2.1. бэлчээрийн мал аж ахуйн уламжлал, өв соёл, заншлыг хамгаалах, түгээн таниулах;

5.2.2. малчинд мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой, хариуцлагатай эрхлэх суурь нөхцөлийг бүрдүүлж, бэлчээрийн мал аж ахуйн онцлогт нийцсэн газар болон байгалийн нөөц ашиглах эрхийг баталгаажуулах;

5.2.3. малчныг мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлж, тэдгээрт насан туршийн боловсрол, мэдлэг олгох, харилцан суралцах, мэдлэг, туршлагаа хуваалцах, малчны залуу халааг бэлтгэх үйл ажиллагааг дэмжих;

5.2.4. малчин, түүний гэр бүлийг орон нутагтаа тогтвор суурьшилтай ая тухтай амьдрах, аж ахуйгаа эрхлэх, сурах эрхийг бүрдүүлэх;

5.2.5. малчны амь ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх;

5.2.6. хөдөөд залуу малчны гэр бүл төлөвлөлттэй хамааралтай хүйсийн тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх;

5.2.7.малчны хөдөлмөрийн үнэлэмж, бүтээмж, хариуцлагатай байдлыг үнэлэх, баталгаажуулах, малчны нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг бэхжүүлэх;

5.2.8.малчны нийгмийн хамгааллын болон санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, хариуцлагатай малчинд болон алслагдсан бүс нутгийн малчинд тухайлсан дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх;

5.2.9.малчны тогтвортой, байгальд ээлтэй ногоон үйлдвэрлэлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулах, нөөц ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэх;

5.2.10.малчны хамтын санаачилга, хоршлыг дэмжиж, малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоог хүлээн зөвшөөрөх, хөгжүүлэх, тэдгээрийн хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх;

5.2.11.малчдын санал, хүсэлтийг жилд нэг удаа хэлэлцдэг малчныг сонсох өдөртэй болгох;

5.2.12.шийдвэр гаргах түвшинд залуу малчдын оролцоог хангах, залуу малчдын гарааны бизнесийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

5.2.13.мал төллөх, ноолуур самнах, хонь ноослох, хавар, намрын технологит ажил, үйлчилгээний үед сургууль, байгууллага, хамт олноор туслах санал санаачилгыг болон илгээлтийн эзэн малчин аяныг тогтмол өрнүүлэх;

5.2.14.залуу малчдад тулгарч байгаа бэрхшээл, тэдгээрт нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох, хариу арга хэмжээ авахад холбогдох талуудын хамтын ажиллагааг нягтруулах, үр дүн гаргах;

5.2.15.хуульд заасан бусад дэмжлэг.

5.3.Төрөөс малчинд үзүүлэх санхүүгийн дэмжлэг дараах хэлбэртэй байна:

5.3.1.малчинд зориулсан санхүү, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, үйлчилгээ;

5.3.2.тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээ;

5.3.3.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;

5.3.4.өрсөлдөх чадвартай түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн урамшуулал;

5.3.5.хуульд заасан бусад.

6 дугаар зүйл.Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих

6.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон захиргааны байгууллага нь малчны тогтвортой үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаатай холбоотой дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.бэлчээрийн эдэлбэр газрын тогтвортой байдлыг хамгаалах, ашиглах эрхийг баталгаажуулахад ахиц гаргах;

6.1.2.орон нутгийн түүхий эдийн нөөц, эрэлт, хэрэгцээг харгалзан мал аж ахуйг кластераар бүсчлэн хөгжүүлэх чиглэлийг батлах;

6.1.3.малчин өрхөөс бэлтгэн нийлүүлэх түүхий эдийг хүлээн авах, анхан шатны боловсруулалт хийх, чанарыг үнэлэх тогтолцоог бүрдүүлж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх;

6.1.4.мал сүргийн бүтэц, нөхөн эргэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй тооцоолох, нөөцийг тодорхойлох, төлөвлөх нэгдсэн арга зүйг улсын хэмжээнд нэвтрүүлэх;

6.1.5.мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг идэвхжүүлэх хөшүүргүүдийг бий болгох;

6.1.6.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг малчин өрх, мал бүхий этгээд тус бүрээр тодорхойлох, бүртгэлжүүлэх, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх;

6.1.7.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэхэд баримтлах стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг малчдад таниулах, сурталчлах;

6.1.8.бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.1.9.хуульд заасан бусад эрх, чиг үүрэг.

6.2.Малчны өөрөө удирдах байгууллага нь малчны тогтвортой үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаатай холбоотой дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

6.2.1.малчин өрх, малчны бүлгийн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, малчны орлого, амьжиргааг дэмжих;

6.2.2.мал, малын гаралтай түүхий эдийг борлуулахад үйлдвэр, малчны уялдааг хангаж, чанартай, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулахад холбох зах зээлийн сүлжээг бий болгох;

6.2.3.малчид бэлчээрийн даацад нийцүүлэн мал аж ахуй эрхлэх, мал сүргийг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах арга, технологийн мэдлэгийг малчдад олгох, сайн туршлагыг хуваалцах;

6.2.4.малчин ахуй, өв соёлд суурилсан аялал жуулчлал түүнийг дагасан үйлчилгээ, эко бүтээгдэхүүн борлуулалтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.2.5.бэлчээрийн төлөв байдлын үнэлгээнд оролцох, сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;

6.2.6.малчин орон нутагтаа гэр, байшин, малын байр, хашаа хорооны нөхцөлөө сайжруулах, шинээр барихад хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлд хамруулах төсөл, хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

6.2.7.хуульд заасан бусад эрх, чиг үүрэг.

6.3.Малчин нь тогтвортой үйлдвэрлэл эрхлэхдээ дараах эрх, үүргийг хүлээнэ:

6.3.1.үйлдвэрлэл эрхлэх газар ашиглахтай холбоотой эрхээ баталгаажуулах;

6.3.2.байгальд ээлтэй, хариуцлагатай байх, үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх;

6.3.3.ашиглагдахгүй байгаа нөөцийг ашиглахад бүтээлч санаачилгатай байх;

6.3.4.бэлчээрийн даацыг зохистой ашиглах, малын чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлээ өргөтгөх, үр ашгийг нэмэгдүүлэх;

6.3.5.мал аж ахуйн үйлдвэрлэлд зохистой дадлыг хэвшүүлж, зах зээлд бэлтгэн нийлүүлэх түүхий эд, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх; орлогоо нэмэгдүүлэх;

6.3.6.өөрийн мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилыг тогтмол сайжруулах малчинд зориулсан сургалтад бүрэн хамрагдах, мэдээлэл, зөвлөгөө авах;

6.3.7.эрх бүхий байгууллагаас гаргасан журам, стандарт, зааврын шаардлагыг мөрдөх;

6.3.8.ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, зах зээлд түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, нийгмийн өмнө хариуцлагатай байх;

6.3.9.төрөөс болон олон улсын байгууллагын санхүүжилтээр олгосон хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх;

6.3.10.мал аж ахуйн технологийн мэргэжлийн ажил, үйлчилгээ үзүүлэгч эрх бүхий этгээдтэй гэрээтэй ажиллах;

6.3.11.малын тоо толгойн өөрчлөлтийн талаарх мэдээг сумын хөдөө аж ахуйн тасагт тухай бүр мэдээлэл өгөх;

6.3.12.малчны талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийн төсөлд санал өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

6.3.13.мал аж ахуйн үйлдвэрлэл шинээр эрхэлж байгаа бол сумын хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлэх, үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд бүртгэлээс хасуулах;

6.3.14.хуулиар хүлээсэн бусад эрх, үүрэг.

6.4.Өөрөө малаа малладаггүй мал өмчлөгч эсхүл үндсэн малчин нь үйлдвэрлэл дээр туслах малчин ажиллуулах тохиолдолд Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хуульд нийцүүлэн гэрээ, хэлцлийг бичгээр байгуулж, түүний ажлын хөлсийг төлөх хэлбэрийг гэрээнд заавал тусгана.

7 дугаар зүйл.Малчны өрсөлдөх чадварыг дэмжих

7.1.Малчны хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг тогтоох арга зүйг бий болгож, үндэсний хэмжээнд нэвтрүүлнэ.

7.2.Малчин, малчны бүлгийн хүсэлтээр мал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд биет үнэлгээ хийх, хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн зөвлөх үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.

7.3.Малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх хүчин зүйлсийг тодорхойлж, эдийн засгийн үр дүнтэй төлөвлөлтөөр малчдын орлого, ашиг, чадамжийг нэмэгдүүлнэ.

7.4.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд чанарын үнэлэмж тогтоож, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

7.5.Хариуцлагатай, тогтвортой, ногоон үйлдвэрлэлтэй мал аж ахуйг эрхлэхэд чиглэгдсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

7.6.Боловсруулах үйлдвэр нь малчин өрх, малчны бүлэгтэй мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтвортой байдлын гэрээг 3 жил тутамд хийдэг тогтолцоонд шилжинэ.

7.7.Сүм, баг бүр мал сүргийг үржил селекцийн хөтөлбөрийн дагуу үржүүлж, малын чанар, ашиг шимийн өсөлт, чанарыг тооцдог системд шилжүүлнэ.

7.8.Эрүүл мал сүрэгтэй малчин өрхийг баталгаажуулж, малын эрүүл мэндийн үйлчилгээг малчин үнэлж, дүгнэдэг болно.

7.9.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтын түвшний өсөлт болон хариуцлагатай байдлын үнэлгээний үзүүлэлтийг улс, аймаг, сумын аварга, малчин, тэргүүний аймаг, сум шалгаруулах болзолд тусгаж, бүтээмжийг үнэлдэг байна.

7.10.Малчдын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны цар хүрээг тэлж, нийлүүлсэн хувь хэмжээгээр ашиг хүртэх, орлогоо өсгөх малчин өрхийн эдийн засгийн чадамжийг сайжруулна.

7.11.Орон нутгийг хөгжүүлэх, мал аж ахуйн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, малчны өрсөлдөх чадвар, нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг бэхжүүлэх, малчны идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн 8-ны өдөр нь “Малчныг сонсох өдөр” байна.

7.12.Малчныг сонсох өдрийн арга хэмжээг энэ хуулийн 23.11-д заасан талуудын оролцоотой хэрэгжүүлнэ.

7.13.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, сумын хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага тус тус хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл.Малчин өрх, тэдгээрийн бүлэгт газар эдэлбэрийн эрхийг баталгаажуулах

8.1.Жилийн 4 улирлын туршид малаа дагнан малладаг малчин өрхийн өвөлжөө, хаваржааны доорх 0,07 га хүртэлх газрын эзэмших эрхийн нэг гэрчилгээг өмчлөх эрхийн гэрчилгээгээр нэг удаа сольж, малчны үйлдвэрлэл явуулахад ашиглах газар эдэлбэрийн эрхийн түвшнийг нэмэгдүүлж, хүйтэн сэрүүнд улиралд мал сүргээ ая тухтай байлгах хашаа, хороондоо хөрөнгө оруулалт хийх эрхийг баталгаажуулна.

8.2.Мал сүргээ идээшлүүлэх зориулалтаар өвөлжөө, хаваржааны болон зуслан, намаржааны бэлчээрийн эдэлбэр газрыг улирлын онцлогтой уялдуулан орон нутгийн бэлчээр ашиглалтын журмын дагуу хязгаарлалттай хүрээнд хамтын оролцоонд тулгуурласан малчны бүлэгт гэрээгээр ашиглуулж болно.

8.3.Энэ хуулийн 8.1, 8.2-д заасан эрхийг албан ёсоор баталгаажуулах чиг үүргийг газрын, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны болон улсын бүртгэлийн байгууллага тус тус хариуцна.

8.4.Мал аж ахуй эрхлэх зориулалтаар бэлчээрийн эдэлбэр газар ашиглуулах гэрээний загварыг газрын болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

8.5.Малчин амины сууц барих, мал аж ахуй эрхлэх зориулалтаар хашаа хороогоо тэлэх, агуулах, байр барих, дэд бүтэц бий болгох, гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих тохиолдолд шаардлагатай газрыг Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

8.6.Малчин өрхөөс шинээр гэр бүл болж өрх тусгаарласан малчин залуу гэр бүл болон хот, суурингаас шилжин очиж, 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд энэ хуулийн 8.1-д заасан эрхийг олгох асуудлыг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын шийдвэрт үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.

8.7.Газрын харилцаатай холбоотой бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохицуулна.

9 дүгээр зүйл.Малчны оролцоотой байгалийн нөөцийн сэргэх чадавхыг бэхжүүлэх

9.1.Бэлчээрийн төлөв байдал, чанарын өөрчлөлтийн явцыг хянах, өөрчлөлтийг цаг тухайд нь илрүүлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагаа нь газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээнд суурилна.

9.2.Бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээ, үр дүнгийн мэдээлэл, зураглалыг ашиглан холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, малчны өөрөө удирдах байгууллага, малчны бүлэг, нөхөрлөл дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.2.1.бэлчээрийн төлөв байдалд үнэлгээ өгөх, эрх зүйн чадамж бүхий, дасан зохицох, даван туулах чадвартай шийдлийг гаргах, сум, аймгийн бэлчээр ашиглалтын журмыг боловсруулж, батлах, мөрдүүлэх;

9.2.2.малчдын оролцоотойгоор бэлчээрт чанарын үнэлгээ хийж, мэдээллийн сан бүрдүүлэх;

9.2.3.малчны бүлгийн саналд суурилан бэлчээрийн ашиглалтыг тохируулах, доройтлоос сэргийлэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, мөрдөх;

9.2.4.бэлчээрийн талбайг малчны бүлэгт урт хугацаагаар ашиглуулах болон хадлангийн талбайг эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх;

9.2.5.бэлчээрийн сэргэх чадавхад суурилсан бэлчээрийн менежментийн нэгдсэн систем, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

9.2.6.бэлчээрийн эдэлбэр газрын ашиглалт, хамгаалалтад байгалийн нөөцийн экосистемд суурилсан зөв дэглэмийг төлөвшүүлэх, уламжлалт ёс заншлыг мөрдөх;

9.2.7.байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

9.2.8.хуульд заасан бусад арга хэмжээ.

9.3.Малчны бүлгийн болон багийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батална.

9.4.Бэлчээрийн даац, хангамжийн түвшнийг тогтоох аргачлал, бэлчээрийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.7.Доройтсон бэлчээрийн нөхөн сэргэх чадавхын ангилал тооцох аргачлалыг хөдөө аж ахуйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

9.8.Бэлчээрийн эдэлбэр газрын талбайн өөрчлөлт, ашиглалттай холбоотой олон нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцогч талууд болон холбогдох бүх шатны малчны өөрөө удирдах байгууллагын төлөөллийг бүрэн хамруулна.

10 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулах

10.1.Аймаг, сум бүр уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр малчид, малчин өрхийн амьжиргаанд нөлөөлөх хүчин зүйлс, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

10.2.Малчин нь эдэлбэр газар, байгалийн нөөцийг ашиглан хувийн өмчийн мал сүргийг адгуулан маллах замаар үйлдвэрлэл явуулахдаа экологийн тогтвортой байдлыг алдагдуулахгүй байх үүрэгтэй.

10.3.Малчин, малчны бүлэг, нөхөрлөл нь учирч болзошгүй гэнэтийн аюул, эрсдэлээс хамгаалж, үйл ажиллагааны борлуулалтын орлогоос хуримтлал үүсгэж, дундын сантай байж болно.

10.4.Эрсдэлийн санд хуримтлал үүсгэх, зарцуулах, хяналт тавих журмыг харилцан тохиролцож, албан ёсоор баталгаажуулсан байна.

10.5.Цаг хүндэрсэн үед малчид отроор нүүдэллэн ашиглах зориулалтаар Монгол Улсын нийт бэлчээрийн эдэлбэр газрын 10-аас доошгүй хувийг улс, аймаг, сумын отрын бүс

нутаг, нөөц бэлчээр болгон хамгаалалтад авах асуудлыг холбогдох төрийн байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

10.6.Энэ хуулийн 10.5-д заасан отрын бүсэд мал оруулах, гаргах харилцааг журмаар зохицуулах ба журмыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох бүтцийн нэгж боловсруулж, аймаг, сумын журмыг тухайн шатны Засаг дарга, аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын нийтлэг журмыг Засгийн газар тус тус батална.

10.7.Уур амьсгалын өөрчлөлтийн хүндрэлийг даван туулахад чиглэгдсэн мэдлэг, мэдээллийг малчдад олгох, үр нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээг олон талт оролцоогоор хэрэгжүүлнэ.

10.10.Малын бэлчээрийн газарт авто зам гаргах, бэлчээрийн хөрсийг эвдэх, бохирдуулах, бэлчээрийн эрүүл ахуйг алдагдуулах, цөл, цөлөрхөг хээрийн бүсийн болон хөрсний эвдрэл, цөлжилт үүсэх нөхцөл бүрдсэн бэлчээрт ургамал түүх, хадахыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МАЛЧНЫ ХӨГЖИЛ

11 дүгээр зүйл.Малчны эрхэмлэх үнэт зүйл

11.1.өв соёл, уламжлал, ёс заншлыг өвлүүлэн хамгаалах;

11.2.байгальд ээлтэй байх, малын ая тухыг хангах;

11.3.эв санааны нэгдлийг эрхэмлэх;

11.4.тогтвортой байдлыг хангах;

11.5.нийгмийн хариуцлага, ёс зүйг ухамсарлах.

12 дугаар зүйл.Малчны мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоо, зарчим

12.1.Малчны мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоо нь малчны үйлдвэрлэл эрхлэх мэдлэгийг дээшлүүлэх, давтан сургах, шинэ болон манлайлагч малчин бэлтгэх, тэдгээрийг тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулах, насан туршийн боловсрол, мэдлэг олгох үйл явцаас бүрдэнэ.

12.2.Малчныг өдөр тутмын мэдээ, мэдээллээр хангах тогтолцоо нь малчны эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлж мэдээллийн сан бүрдүүлэх, нэг цонхны цахим хөтөч системд суурилна.

12.3.Энэ хуулийн 12.1-д заасан боловсрол, мэдлэг олгох сургалтыг мал аж ахуйн чиглэлийн боловсрол, сургалт хариуцсан төрийн байгууллага удирдаж, мэргэжил, сургалт үйлдвэрийн төв, коллеж, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулна.

12.4.Малчныг сургах сургалтын нэгдсэн стандарт, бүс нутгийн онцлогт нийцүүлсэн сургалтын хөтөлбөртэй байна.

12.5.Энэ хуулийн 12.3-д заасан байгууллага нь малчны сургалтын нэгдсэн стандарт, хөтөлбөрийг багцлан боловсруулах ба хөтөлбөрт дор дурдах чиглэлийн мэдлэг, ур чадварыг заавал олгохоор тусгана:

12.5.1.бэлчээрийн мал аж ахуй эрхлэх онцлог, давуу ба сул тал;

12.5.2.мал маллах, цаг уур, байгаль шинжих уламжлалт арга барил, туршлага, өв соёл, заншил;

12.5.3.мал аж ахуйн салбарын хөгжлийн чиг хандлага, нийгмийн эрэлт, хэрэгцээ, шаардлага, технологийн хөгжил дэвшил;

12.5.4.мал маллах, тэжээх, арчлах, үржүүлэх, эрүүл мэндийг хамгаалах технологийн мэдлэг;

12.5.5. бэлчээрийн сэргэх чадавхыг бэхжүүлэх арга замууд;

12.5.6.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх стандартууд;

12.5.7.зах зээлд нэвтрэх, бүтээгдэхүүн хөгжүүлэх, үр ашигтай бизнес эрхлэх арга замууд, малчин өрхийн баталгааны тэмдгийг хэрэглэх ач тус;

12.5.8.малчны хамтын хоршил, хариуцлагатай шийдвэр гаргах, манлайлах чадварыг хөгжүүлэх боломж;

12.5.9.ногоон үйлдвэрлэл, ухаалаг мал аж ахуй эрхлэх арга, технологи, ач холбогдол;

12.5.10.малчдын нийгмийн болон эрүүл мэндийн, эд хөрөнгийн даатгалын ач холбогдол;

12.5.11.малын тоо толгойн албан татварын тайланг цахимаар гаргах, малчны цахим хөтөч, төрийн үйлчилгээний цахим системийг ашиглах аргачлал.

12.6.Энэ хуулийн 12.4-д заасан хөтөлбөр, залуу малчин, гэрээт, туслах малчны, манлайлагч малчны болон давтан сургах сургалтын хөтөлбөр, үргэлжлэх хугацаа,

сургалт явуулах, үнэлэх хэлбэрийг энэ хуулийн 12.3-д заасан байгууллагын сургалтын хөтөлбөр хариуцсан хорооны хурлаар хэлэлцэж баталсан байна.

12.7.Малчны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургагч багшийг төрөлжүүлэн бэлтгэх, эрх олгох асуудлыг энэ хуулийн 12.3-д заасан байгууллага хариуцна.

12.8.Сургалтын хөтөлбөрөөр бүрэн суралцсан, үнэлгээний шаардлага хангасан төгсөгчид малчин мэргэжлийн үнэмлэх, тэмдэг олгоно.

12.9.Малчныг давтан сургах сургалтыг малчинд мэргэжлийн үнэмлэх олгосон хугацаанаас хойш тооцох ба сургалт хоорондын зай 3-5 жил байна.

12.10.Манлайлагч малчны сургалтын хөтөлбөрт хамрагсдад энэ хуулийн 12.8-д заасан хугацаа хамаарахгүй ба тус сургалтын хөтөлбөрөөр бүрэн суралцсан малчны мэргэжлийн үнэмлэх олгоно.

12.11.Сургалтын явцад гарын авлага, нэмэлт мэдээллээр хангах, төгсөгчид мэргэжлийн үнэмлэх олгох, мэдээллийг бүртгэлийн нэгдсэн системд оруулах асуудлыг тухайн сургалтыг зохион байгуулсан эрх бүхий байгууллага хариуцна.

12.12.Малчин мэргэжлээр суралцагч нь сургалтын зардлаа өөрийн болон бусад тэтгэлгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

12.13.Мал маллаж байгаа малчин мэргэжлээр албан ёсоор суралцаагүй, сургалтаа төгсгөөгүй, өмнө нь малчин мэргэжлийн үнэмлэх авсан малчинд нас, ажилласан жил, үнэмлэх олгосон хугацаа зэргийг харгалзан мэргэжлийн үнэмлэхийг шинэчлэх, сунгах арга хэмжээг зохион байгуулна.

12.14.Энэ хуулийн 12.13-т заасан арга хэмжээг аймаг, дүүргийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын судалгаанд суурилж, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран мал аж ахуйн чиглэлийн боловсрол, сургалт хариуцсан төрийн байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

12.15.Энэ хуулийн 12.14-д заасан ажлын үр дүнгээр хариуцсан байгууллага мэдээллийн цахим сан бүрдүүлсэн байна.

13 дугаар зүйл. Малчны хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр

13.1.Олон талт хамтын оролцоонд түшиглэн амьдрах ухаан, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, малчны залуу халааг бэлтгэх зорилго бүхий насан туршийн мэдлэг, боловсролыг малчинд олгоно.

13.2.Мал аж ахуйн үйлдвэрлэлд суурилсан эдийн засагтай орон нутгийн засаг захиргааны нэгж нь малчдад төрийн бодлого, хууль эрх зүйн мэдлэг олгох, харилцан мэдлэг,

туршлагаа солилцох, залуу үеэ бэлтгэх таатай орчныг бүрдүүлсэн Малчны хөгжлийн сургалт, мэдээллийн төв эсхүл тэнхимтэй /цаашид “Малчны хөгжлийн төв” гэх/ байна.

13.3.Орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны хөгжлийг дэмжихэд чиглэсэн Малчны хөгжлийн төсөл, хөтөлбөрийг сум, аймаг бүр боловсруулж, хэрэгжүүлэх ба тэтгэлгээр суралцах мэргэжлийн тэргүүлэх чиглэлд малчны мэргэжлийг хамруулахаар тусгана.

13.4.Сумын төрийн захиргааны байгууллага нь малчинд насан туршийн боловсрол, мэдлэг олгохтой холбогдуулан дараах чиг үүргийг хариуцан хэрэгжүүлнэ:

13.4.1.малчид, малчны бүлэг, хэсгээс гарсан санал, хүсэлтэд суурилан малчныг сургах, шинээр бэлтгэх, давтан сургах сумын жил бүрийн төлөвлөлтийг боловсруулах, холбогдох сургалтын байгууллагад захиалга өгөх;

13.4.2.малчдаас нөлөө бүхий төлөөллийг сонгож, манлайлагчийн сургалтын хөтөлбөрт хамруулах;

13.4.3.орон нутагт мал аж ахуйн чиглэлээр зохион байгуулагдаж байгаа аливаа сургалт, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт малчдын оролцоог хангах;

13.4.4.Малчны хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулах зардлыг жил бүрийн төсөвт тусгах;

13.4.5.ахмад малчдын туршлагыг залуу малчдад өвлүүлэх чиглэлээр санал, санаачилгатай ажиллах;

13.4.6.мал аж ахуйн уламжлалт мэдлэгийг сумын хэмжээнд бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх;

13.4.7.хуульд заасан бусад чиг үүрэг.

13.5.Энэ хуулийн 13.3-т заасан төсөл, хөтөлбөрийг аймаг, сумын Засаг дарга тус тус баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

13.6.Энэ хуулийн 13.3, 13.4.4-т заасан төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг тухайн шатны төсвийн захирагч нар жил бүрийн төсөвт тусгаж, батлан хэрэгжүүлнэ.

13.7.Энэ хуулийн 13.6-д заасан төсвийг малын тоо толгойн албан татвараас төвлөрөх орлогын эх үүсвэрээс бүрдүүлэх асуудлыг холбогдох журамд заасны дагуу хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

13.8.Малчны хөгжлийн төвийн ажиллах журмыг тухайн багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батална.

13.9.Малчин нь боловсрол, мэдлэг, ур чадвараа сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх талаар харьяалах орон нутгийн төрийн захиргааны байгууллагад санал, хүсэлт, гомдол гаргана.

13.10.Малчны хөгжлийн индексийг сум, аймаг, үндэсний түвшинд 3 жил тутамд тодорхойлж байна.

13.11.Малчны хөгжлийн индексийг аймаг, сум, улсын аварга малчин болон тэргүүний аймаг, сум, дүүрэг шалгаруулах шалгуур үзүүлэлтэд харгалзан үзнэ.

13.12.Малчны хөгжлийн индексийг тооцох аргачлалыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран баталж, үр дүнд хяналт тавина.

14 дүгээр зүйл.Малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх

14.1.Бэлчээрийн мал аж ахуй, малчны үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

14.1.1.мэдээллийн шуурхай, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, орон зайн хамаарлыг бууруулах;

14.1.2.ил тод, шуурхай цахим засаглалын үйлчилгээг нэвтрүүлэх;

14.1.3.харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан инновац, бүтээмж, өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх;

14.1.4.суурь дэд бүтцийг сайжруулах, мэдээллийн их өгөгдөлд суурилсан системийг нэвтрүүлэх;

14.1.5.дижитал мал аж ахуйн эдийн засгийн бүтцэд шилжих.

14.2.Малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлж, цахим малчныг хөгжүүлнэ:

14.2.1.хөдөлгөөнт холбоо, телевиз, интернэт сүлжээний үйлчилгээ;

14.2.2.мэдээлэл авах, солилцох нэг цонхны цахим үйлчилгээ;

14.2.3.банк, санхүү, татвар, төлбөр, тооцоо, худалдааны цахим үйлчилгээ;

14.2.4.төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний цахим систем;

14.2.5.малын тооллого, бүртгэлийн систем;

14.2.6.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гарал үүсэл аюулгүй байдлын мөшгөх систем баталгаажуулалт, цахим худалдаа, захиалга;

14.2.7.гойд ашиг шимт, шилмэл малын үзэсгэлэн, дуудлага худалдаа, захиалга, малын тэжээл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн цахим худалдаа;

14.2.8.газрын бүртгэл, кадастрын зураглал, бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээний үйлчилгээ;

14.2.9.технологийн сүлжээгээр дамжуулан малчдад мэдлэг түгээх бусад цахим үйлчилгээ.

14.3.Малчны болон тэдгээрийн үйл ажиллагааны бүртгэл нь хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын болон улсын бүртгэлийн, татварын, статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим бүртгэлээр тус тус баталгаажна.

14.4.Малын өмчийн эзэн, малчин, мал бүхий этгээд нь жилд нэг удаа малын тоо толгойн албан татварын тайланг холбогдох журам, маягтын дагуу татварын удирдлагын нэгдсэн системд цахимаар хүргүүлнэ.

14.5.Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс олгож байгаа мөнгөн урамшууллын мэдээллийг хөдөө аж ахуйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэж, цахим сан үүсгэж, архивлана.

14.6.Малчин нь маллаж байгаа мал, түүний шилжилт, хөдөлгөөн, гарал үүслийн талаарх мэдээллийг Малын генетик нөөцийн тухай хуулийн 5.5-д болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.4.3-д заасны дагуу тухай бүрт цахимаар бүртгүүлнэ.

14.7.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг малчны хотноос эцсийн хэрэглэгчийн гар дээр тавих хүртэл алхам бүрд хийгдсэн үйл ажиллагааг мэдээлэл технологид суурилсан баталгаажуулалтад үндэслэн хийнэ.

15 дугаар зүйл.Малчны цахим хөтөч

15.1.Энэ хуулийн 12.2-д заасан Малчны цахим хөтөч нь дараах мэдээллээс бүрдэнэ:

15.1.1.малчны үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомж, эрх зүйн акт; стандартын талаарх мэдээлэл;

15.1.2.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн мэдээлэл;

15.1.3.мал маллах, отор нүүдэл, хийх, байгаль цаг уурыг шинжих, ул мөр багатай амьдрах зэрэг уламжлалт мэдлэг, зан заншил, өв соёлын талаарх мэдээлэл;

15.1.4.малын чанарыг сайжруулах, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэргэх чадавхад суурилсан бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн мэдлэг олгох мэдээлэл, цуврал хичээл;

15.1.5.малчны сайн туршлагын мэдээлэл, ярилцлага, хэлэлцүүлэг;

15.1.6.эдийн засгийн үр ашигтай үйлдвэрлэл эрхлэх тухай зөвлөмж, банк санхүүгийн байгууллагын мэдээлэл;

15.1.7.эрдэм шинжилгээний байгууллага, судлаачийн бүтээл, өгүүллэг, ярилцлага, зөвлөмж;

15.1.8.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр, цехийн талаарх мэдээ, мэдээлэл;

15.1.9.мал аж ахуйн үйлдвэрлэл, малчны дунд хэрэгжүүлж байгаа гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, буцалтгүй тусламж, зээлийн талаарх мэдээлэл;

15.1.10.гадаад, дотоодын үзэсгэлэн, худалдаа, техник, технологийн хөгжлийн талаарх мэдээ, мэдээлэл;

15.1.11.хуулиар нууцад хамааруулаагүй бусад мэдээлэл.

15.2.Малчны цахим хөтчийг мэргэжлийн чиглэлийн төрийн үйлчилгээний эсхүл иргэний нийгмийн байгууллага хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулж, ажиллуулна.

15.3.Малчны цахим хөтчийн тухай журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МАЛЧНЫ БҮТЭЭМЖ, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

16 дугаар зүйл.Малчны үйлдвэрлэлийн цар хүрээ, чадавх, бүтээмжийн ангилал

16.1.Жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа малчин өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хэв шинжийг үйл ажиллагааны цар хүрээ, хөдлөх хөрөнгө, борлуулалтын орлоготой уялдуулж, дор дурдсанаар ангилна:

16.1.1.хонин толгойд шилжүүлснээр 350 хүртэл малтай буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 75 дахин үржүүлсэнтэй тэнцүү төгрөг хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй, түүнтэй тэнцэх жилийн борлуулалтын орлоготой малчин өрх;

16.1.2.хонин толгойд шилжүүлснээр 351-700 хүртэлх малтай буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 76-150 дахин үржүүлсэнтэй тэнцүү төгрөг хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй, түүнтэй тэнцэх жилийн борлуулалтын орлоготой малчин өрх;

16.1.3.хонин толгойд шилжүүлснээр 701-1000 хүртэлх малтай буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 151-300 дахин үржүүлсэнтэй тэнцүү төгрөг хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй, түүнтэй тэнцэх жилийн борлуулалтын орлоготой малчин өрх;

16.1.4.хонин толгойд шилжүүлснээр 1001-2000 хүртэлх малтай буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-450 дахин үржүүлсэнтэй тэнцүү төгрөг хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй, түүнтэй тэнцэх жилийн борлуулалтын орлоготой малчин өрх;

16.1.5.хонин толгойд шилжүүлснээр 2001-5000 хүртэлх малтай буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 450-750 дахин үржүүлсэнтэй тэнцүү төгрөг хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй, түүнтэй тэнцэх жилийн борлуулалтын орлоготой малчин өрх.

16.2.Энэ хуулийн 16.1.1, 16.1.2-д заасан үйлдвэрлэлийг өрхийн, 16.1.2-16.1.5-д заасан үйлдвэрлэлийг өргөтгөсөн үйлдвэрлэлд хамааруулна.

16.3.Өрхийн болон өргөтгөсөн үйлдвэрлэл эрхэлж байгаа цар хүрээг энэ хуульд заасан дэмжлэгийг үзүүлэхэд харгалзана.

16.4.Малчин өрхийн үйлдвэрлэлийн хэв шинжийн ангиллыг тогтоох болон бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлд бүтээмж тооцох аргачлалыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, статистикийн байгууллага хамтран боловсруулж, батална.

17 дугаар зүйл. Малчны мэргэшлийн үнэлэмж, баталгаажуулалт

17.1.Жилийн 4 улирлын туршид малаа маллаж байгаа малчинд мал маллах мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг нь харгалзан мэргэшлийн зэрэг олгоно.

17.2.Малчны мэргэшлийн зэрэг нь дараах 3 шатлалтай байна:

17.2.1.ахлах;

17.2.2 тэргүүлэх;

17.2.3.зөвлөх;

17.3.Энэ хуулийн 17.2.1-д заасан зэргийг 8-10 хүртэл жилийн хугацаанд тасралтгүй малчнаар ажилласан туршлагатай, энэ хуулийн 12.8-д заасан шаардлагыг хангасан, бусдыг манлайлах, хариуцлагатай шийдвэр гаргах чадамжтай малчинд олгоно.

17.4.Энэ хуулийн 17.2.2-д заасан зэргийг 11-18 хүртэл жилийн хугацаанд тасралтгүй малчнаар ажилласан туршлагатай, энэ хуулийн 12.8, 12.10-д заасан шаардлагыг хангасан, бусдыг манлайлах, хариуцлагатай шийдвэр гаргах чадамжтай малчинд олгоно.

17.5.Энэ хуулийн 17.2.3-д заасан зэргийг 19 ба түүнээс дээш жилийн хугацаанд тасралтгүй малчнаар ажилласан туршлагатай, бусдыг манлайлах, сургах, бусдад зөвлөх, хариуцлагатай шийдвэр гаргах чадамжтай малчинд олгоно.

17.6.Малчинд мэргэшлийн зэргийг гэрчлэх үнэмлэх олгох ба зэргийг шатлал алгасаж олгохгүй.

17.7.Малчинд мэргэшлийн зэрэг олгох, бүртгэх асуудлыг орон нутгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

17.8.Энэ хуулийн 13.2-д заасан байгууллага мэргэшлийн зэрэг олгосон тухай бүртгэлийг мал аж ахуйн салбарын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, холбогдох баримт бичгийг архивын нэгж болгон хадгална.

17.9.Малчинд мэргэшлийн зэрэг, үнэмлэх олгох, бүртгэх урамшуулах журам, үнэмлэхний загварыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.10.Энэ хуулийн 17.2.2, 17.2.3-д заасан мэргэшлийн зэрэгтэй малчин нь малчдыг сургах, дадлагажуулан сургах эрхтэй байна.

17.11.Залуу малчдад зөвлөн тусалсан ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэгтэй малчин нь энэ талаар тэмдэглэл хөтлөх ба энэ нь сум, аймаг, улсын аварга малчин шалгаруулах, урамшуулахад харгалзах үзүүлэлт болно.

17.12.Тэргүүлэх, зөвлөх зэрэгтэй малчнаас зөвлөгөө авсан малчин түүнийг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр урамшуулж болно.

18 дүгээр зүйл. Малчны хариуцлагатай байдалд тавигдах шаардлага, шалгуур

18.1.Малчны хариуцлагатай байдлыг малчин өрх, малчны бүлэг, хэсэг, баг, сумын түвшинд тодорхойлох ба дараах чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадлыг нэвтрүүлсэн байдлыг тогтооно:

18.1.1.байгалийн нөөц, бэлчээр, тэжээл, усны хангамжийн зөв зохистой ашиглалт;

18.1.2.мал маллах, тэжээх, арчлах арга барил, технологийн малд ээлтэй байдал;

18.1.3.мал сүргийн нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг селекцийн ажлын зохион байгуулалт, чанар, бүтээмж;

18.1.4.малын эрүүл мэнд, аюулгүй байдал;

18.1.5.малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанар, бэлтгэн нийлүүлэлтийн түвшин.

18.2.Энэ хуулийн 18.1.1-д заасан зохистой дадлыг дараах шаардлага, шалгуурыг хангасан байна:

18.2.1.малчин өрх, хот айл нь бэлчээр нутгаа дундаа хамтран ашиглаж ирсэн уламжлал дээрээ үндэслэн харилцан зөвшилцөж, дүрмээ баталгаажуулан малчны бүлэг, хэсгийн зохион байгуулалтад орсон;

18.2.2.бэлчээрийн мал аж ахуйн уламжлалыг хадгалж, жилийн 4 улиралд 4 ба түүнээс дээш удаа нүүдэлж, мал сүргийн ая тухтай байдлыг хангадаг, бэлчээрийн менежментийн зохистой дадлуудыг хэрэгжүүлсэн;

18.2.3.гэрээний дагуу ашиглаж байгаа бэлчээр, хадлангийн газарт жил бүр сумын газрын даамал бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээ хийлгэсэн байдалд хяналт тавьдаг;

18.2.4.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн ургац нэмэгдүүлэх, сайжруулах арга хэмжээг жил бүр хэрэгжүүлсэн, бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулаагүй;

18.2.5.бэлчээрийн даацыг тухайн экологийн бүсийн хэвийн хэмжээнээс хэтрүүлээгүй, бэлчээрийн ачаалал суурь жилтэй харьцуулахад нэмэгдээгүй.

18.3.Энэ хуулийн 18.1.2-д заасан зохистой дадалд дараах шаардлага, шалгуурыг хангасан байна:

18.3.1.малын хэрэгцээ, шаардлагыг хангахуйц өвөлжөө, хаваржааны хашаа, саравч, хороо, байр, зөөврийн хашаатай байх;

18.3.2.дөрвөн улиралд нүүдэллэж байршихдаа орчны хогийг цэвэрлэж, байгаль орчин бохирдуулахгүй, хог хаягдал үлдээдэггүй байх;

18.3.3.малын хэвтэр бууц, хашаа хороог байнга цэвэрлэж, өвөлжөөний хөрзөнг жил бүр авдаг, ахуйн хогийг төвлөрсөн цэгт байршуулж, устгадаг байх;

18.3.4.мал маллах ээлтэй арга ашигласан байх;

18.3.5.мал сүргийг жилд 300 ба түүнээс дээш хоногийн хугацаанд байгалийн бэлчээрт бэлчээрлүүлэх, хэрэгцээт эрдэс тэжээлээр хангах;

18.3.6.малын өвөлжилт, хаваржилтад зориулж 90-ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц өвс, нэмэгдэл тэжээл бэлтгэж нөөцлөх;

18.3.7.уст цэг, худаг, хөв цөөрөм бий болгох, сэргээн засварлахад хөрөнгө оруулалт хийж, хэрэглэх усны чанар, эрүүл ахуйд үнэлгээ хийлгэсэн байх;

18.3.8.мал хариулах, тууварлахдаа уламжлалт аргаар ашигласан байх;

18.3.9.малыг тусгайлан бэлтгэсэн эсхүл зориулалтын тээврийн хэрэгсэл ашиглан тээвэрлэдэг байх.

18.4.Энэ хуулийн 18.1.3-д заасан зохистой дадалд дараах шаардлага, шалгуурыг хангасан байна:

18.4.1.эрх бүхий байгууллагаас тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн үүлдрийн малтай, хээлтүүлэгч мал нь үржлийн гэрчилгээтэй, бүртгэлтэй байх;

18.4.2.нийт мал сүргийн 30 хүртэлх хувийг тухайн жилд эдийн засгийн эргэлтэд оруулж, борлуулдаг байх;

18.4.3.нэг малаас авч буй ашиг шимийн дундаж гарц, малын амьдын жин, махны гулуузны жин стандартад заасан тоо, хэмжээнд болон түүнээс дээш байх;

18.4.4.малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 3 жил тутамд чанарын үнэлгээ хийлгэх;

18.4.5.малын үржүүлэг, технологийн үйлчилгээг мэргэжлийн нэгж, мэргэжилтнээс авах, гэрээ байгуулах;

18.4.6.хээлтүүлэгчийн хүрэлцээг тогтоосон нормд байхаар зохион байгуулах, малын шилжилт хөдөлгөөний талаар мэргэжлийн байгууллагад заавал мэдээлнэ.

18.5.Энэ хуулийн 18.1.4-д заасан зохистой дадалд дараах шаардлага, шалгуурыг хангасан байна:

18.5.1.малын гоц халдварт, халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлсэн байх;

18.5.2.малын эрүүл мэндийн түүхийг мөшгөх нөхцөлийг бүрдүүлж малын шилжилт хөдөлгөөнийг хянадаг, мэдээлдэг байх;

18.5.3.малын эм болон төрөл бүрийн химийн бэлдмэлийн хэрэглээний зохистой дадлыг нэвтрүүлэх, эмийн үлдэгдэл агуулаагүй, баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх.

18.6.Энэ хуулийн 18.1.5-д заасан зохистой дадалд дараах шаардлага, шалгуурыг хангасан байна:

18.6.1.бэлтгэсэн болон борлуулсан түүхий эд бүтээгдэхүүний бүртгэлийг хөтөлж, гарал үүсэл, аюулгүй байдал, чанарыг мөшгөх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

18.6.2.түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг үнэлүүлж, суурь түвшнийг сайжруулах арга замыг боловсруулж, мөрдөн ажиллаж байгаа;

18.6.3.малын ноос, ноолуурыг технологийн хугацаанд холбогдох стандартын шаардлагын дагуу нас, хүйс, өнгөний ялгаатай байдлаар ангилж, үйлдвэрт ээлтэй нягт, тааран шуудай, баглаа боодолд савлаж, бэлтгэн нийлүүлдэг;

18.6.4.малын арьс ширийг эсгэж, огтлохгүйгээр өвчиж, хоёр цагийн дотор цэвэрлэгээ, анхан шатны тордолтыг хийж, холбогдох стандартын шаардлагын дагуу чанарын хамгаалалттайгаар бэлтгэх;

18.6.5.малын сүүг түүхий сүүнд тавигдах ерөнхий шаардлагын стандартыг ханган бэлтгэж, сав суулга нь эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй байдлыг хангасан байх;

18.6.6.малын мах бэлтгэлийг хийхдээ холбогдох стандартын дагуу төхөөрдөг байх.

19 дүгээр зүйл. Хариуцлагатай байдлыг үнэлэх, баталгаажуулах

19.1.Малчны хариуцлагатай байдлыг стандартаар тогтоосон зохистой дадлын шаардлага, шалгуурыг хангасан байдлыг үнэлж, баталгаажуулна.

19.2.Хариуцлагатай байдлын үнэлгээ, баталгаажуулалтыг малчин өрх, малчны бүлэг, баг, сумын түвшнээр хийнэ.

19.3.Хариуцлагатай байдлын үнэлгээ дараах 2 үе шаттай байна:

19.3.1.өөрийн үнэлгээ;

19.3.2.хөндлөнгийн үнэлгээ.

19.4.Хариуцлагатай байдлаа баталгаажуулах хүсэлттэй этгээд өөрийн үйл ажиллагаа нь зохистой дадлын шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлж, дүгнэх замаар энэ хуулийн 19.3.1-д заасан үнэлгээг гүйцэтгэнэ.

19.5.Өөрийн үнэлгээгээр зохистой дадлын шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байгаа тохиолдолд малчны бүлэг, баг, сум нь хөндлөнгийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг стандартчилал, хэмжил зүйн газарт ирүүлнэ.

19.6.Энэ хуулийн 19.3.2-д заасан үнэлгээг стандартчилал, хэмжил зүйн газраас итгэмжлэлийн гэрчилгээ олгосон эрх бүхий баталгаажуулалтын байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

19.7.Энэ хуулийн 19.5-д заасан байгууллага нь эрх бүхий шинжээчийн багийг томилж, хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ба шинжээчийн баг үнэлнэ.

19.8.Энэ хуулийн 19.6-д заасан үнэлгээний үр дүнд зохистой дадлын шаардлага, шалгуурыг бүрэн хангасан этгээдэд хариуцлагатай малчин баталгаажуулалтын гэрчилгээг Баталгаажуулалтын зөвлөлийн шийдвэрт үндэслэн олгоно.

19.9.Хөндлөнгийн үнэлгээгээр зохистой дадлын шаардлага, шалгуурын түвшнийг 90 ба түүнээс дээш хувиар хангасан этгээдэд зөвлөмж өгч, зөвлөмжид үл тохирлыг залруулах хугацааг заана.

19.10.Энэ хуулийн 19.8-д заасан үл тохирлыг залруулсан этгээд хөндлөнгийн давтан үнэлгээнд орж болно.

19.11.Энэ хуулийн 19.7-д заасан гэрчилгээг авсан этгээдийн үйл ажиллагаанд 12-14 сарын дараа хяналт хийж, тогтвортой байдлыг баталгаажуулна.

19.12.Энэ хуулийн 19.5-д заасан байгууллага нь орон тооны болон орон тооны бус шинжээч болон баталгаажуулалтын зөвлөлтэй байх ба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.12.1.хүсэлт гаргасан этгээдийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх;

19.12.2.зохистой дадлын үйл ажиллагаанд газар дээр нь үнэлгээ хийх;

19.12.3.үл тохирлыг засан залруулах хугацааг зааж, сайжруулахыг санал болгох;

19.12.4.баталгаажуулалтын үнэлгээний тайланг баталгаажуулалтын зөвлөлд тайлагнах;

19.12.5.баталгаажуулалтын шийдвэр гаргах, гэрчилгээ олгох;

19.12.6.баталгаажуулалтын гэрчилгээ авсан этгээд нь стандартын шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байгаа эсэхийг баталгаажуулж, жил бүр магадлах шалгалтыг хийх;

19.12.7.мэргэжлийн шинжээчдийг сургах, давтан бэлтгэх.

19.13.Баталгаажуулалтын зөвлөлийн шийдвэр нь хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн этгээдийн холбогдох бичиг баримт, эх сурвалжийн мэдээлэл, үнэлгээний багийн тайлангийн нотолгоонд суурилна.

19.14.Энэ хуулийн 19.12.6-д заасан магадлах шалгалтыг анхны баталгаажуулалтаас хойш 14 хүртэлх сарын дотор хийнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

МАЛЧНЫ ХАМТЫН САНААЧИЛГА, ХОРШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ИДЭВХЖҮҮЛЭХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

20 дугаар зүйл.Малчны хамтын санаачилга, хоршил, кластерын үйл ажиллагаа

20.1.Малчны хамтын санаачилга, хоршил нь дараах хэлбэртэй байна:

20.1.1.малчны бүлэг;

20.1.2.бэлчээр ашиглагчдын хэсэг;

20.1.3.малчны нөхөрлөл;

20.1.4.малчны өөрөө удирдах байгууллага;

20.1.5.малчны хоршоо.

20.2.Энэ хуулийн 20.1.1-20.1.4-д заасан малчны хамтын хоршлын хэлбэр нь Иргэний хуулийн 481.1, 481.2-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдаж, үйл ажиллагааны чиглэл, хамтран ажиллах хэлбэрээ харилцан тохиролцож, зөвшилцөн, тэдгээрийг дүрмээр баталгаажуулсан байна.

20.3.Энэ хуулийн 20.1.5-д заасан хоршооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа Хоршооны тухай хуулиар зохицуулагдана.

20.4.Малчны хамтын санаачилга, хоршлыг төрөөс дараах байдлаар дэмжинэ:

20.4.1.хамтран ажиллах хорших, төрөлжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

20.4.2.дэд бүтцийн хангамжийг сайжруулах;

20.4.3.мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлт, үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрт малчны хувь нийлүүлсэн оролцоог дэмжих;

20.4.4.малчин өрхийн орлогыг бууруулахгүйгээр бэлчээрийн даацаас хэтэрсэн малын тоог үе шаттай бууруулах, малыг борлуулах үр дүнтэй арга, тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх;

20.4.5.малчны санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, малчны эдийн засгийн чадамжийг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны цар хүрээг тэлэх, санхүүгийн хүртээмжтэй байдал, чадамжийг нэмэгдүүлэх;

20.4.6.малчин, малчны бүлгийн санал, санаачилгаар цас борооны ус тогтоох, усан сан, нуур, хөв, цөөрөм байгуулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах, малын өвс, тэжээл бэлтгэх, нөөцлөхөд зээлийн бодлогыг хэрэгжүүлэх;

20.4.7.хуульд заасан бусад.

20.5.Хамтын зохион байгуулалтын нэгдэл, кластерын үйл ажиллагаа эрхлэх.

21 дүгээр зүйл.Малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоо

21.1.Малчид үйл ажиллагааны чиглэлийн дагуу сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, гишүүддээ үйлчилдэг малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоог бүрдүүлж болно.

21.2.Малчны өөрөө удирдах байгууллагын тогтолцоо нь багийн түвшинд малчны бүлэг, хэсэг, нөхөрлөл , сум, аймгийн түвшинд холбоо, үндэсний хэмжээнд иргэний нийгмийн байгууллагын нэгдсэн холбоо гэсэн шаталсан хэлбэрээр зохин байгуулагдаж, үйл ажиллагаа явуулна.

21.3.Малчны бүлэг, нөхөрлөл нь малаа жилийн 4 улирлын туршид маллаж байгаа үндсэн ба туслах малчдын сайн дурын гишүүнчлэлээс бүрдэнэ.

21.4.Малчны бүлэг, нөхөрлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.4.1.гишүүний хууль ёсны эрх ашгийг хамгаалах, түүнийг төлөөлөх;

21.4.2.малчны бүлэг, нөхөрлөлийн дүрэм, үйл ажиллагааны чиглэлээр байгуулсан гэрээг мөрдөх.

21.5.Малчны өөрөө удирдах тогтолцооны сумын холбоо /цаашид “сумын холбоо” гэх/ нь энэ хуулийн 21.3-д заасан этгээдийн сайн дурын гишүүнчлэлээс бүрдэнэ.

21.6.Сумын холбоо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.6.1.гишүүний хууль ёсны эрх ашгийг хамгаалах, түүнийг төлөөлөх;

21.6.2. гишүүний тулгамдсан асуудлуудыг нэгтгэн тодорхойлох, зөвлөгөө, мэдээллээр хангах;

21.6.3. шинээр малчны бүлэг, хэсэг байгуулах, холбоонд элсэх хүсэлтэй малчинд холбооны үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулах, санал, хүсэлт хүлээн авах;

21.6.4. гишүүн малчныг сургах чиглэлээр судалгаа тогтмол хийх, холбогдох сургалтад хамруулах;

21.6.5. гишүүн нөөц бололцоогоо ашиглах, төрөл бүрийн үйлчилгээ хүртэх боломжийг нэмэгдүүлэх;

21.6.6. гишүүн байгалийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран зохион байгуулах;

21.6.7. гишүүнчлэлийг өргөжүүлэх, холбоог хөгжүүлэх арга хэмжээг авах;

21.6.8. хуульд заасан бусад чиг үүрэг.

21.7. Малчны өөрөө удирдах тогтолцооны аймгийн холбоо /цаашид “аймгийн холбоо” гэх/ нь энэ хуулийн 21.5-д заасан этгээдийн сайн дурын гишүүнчлэлээс бүрдэнэ.

21.8. Аймгийн холбоо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.8.1. гишүүнчлэлийг өргөжүүлэх, холбоог хөгжүүлэх арга хэмжээг авах;

21.8.2. холбооны үйл ажиллагаа, санхүүгийн байдал, гишүүнчлэлтэй холбоотой мэдээллийг гаргуулан авах;

21.8.3. холбооны нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайланг гаргахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

21.8.4. малчдын хоорондын хамтын ажиллагааг урамшуулан, хөгжүүлэх

21.8.5. холбооны санхүү, зах зээл, бизнесийн орчны судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл өгөх;

21.8.6. малчдад мэдээлэл түгээж, тэдний туршлагаа хуваалцах боломжийг нээж өгөх, шаардлагатай өрхийг малжуулах арга хэмжээг холбогдох талуудтай хамтран зохин байгуулах;

21.8.7. гишүүн, ажилтныг сургах, давтан сургах мэргэжил, арга зүйгээр дэмжих

ажлыг зохион байгуулах;

21.8.8.хуульд заасан бусад чиг үүрэг.

21.9.Малчны өөрөө удирдах тогтолцооны нэгдсэн холбоо /цаашид “нэгдсэн холбоо” гэх/ нь энэ хуулийн 21.7-д заасан этгээдийн сайн дурын гишүүнчлэлээс бүрдэнэ.

21.10.Нэгдсэн холбоо нь дараах ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.10.1.малчны бүлэг, хэсгийн эрх ашгийг хамгаалах;хоршооллын салбарын хөгжлийн нэгдсэн бодлого, хоршооллын хөдөлгөөнийг өргөжүүлэх талаар төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;

21.10.2.малчны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар төрийн болон иргэний нийгмийн, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

21.10.3.мал аж ахуйн үйлдвэрлэлийн болон малчны хөгжлийн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр судалгаа хийх, санал боловсруулах;

21.10.4.малчин, малчны бүлэг, хэсэг, нөхөрлөлийн хөгжлийн түвшин, чадавхын үнэлгээ хийх арга зүй, шалгуур үзүүлэлтийг тогтоон мөрдүүлэх малчны талаарх судалгааг тогтмол цуглуулж, тэдгээрийг хөгжүүлэх, дэмжихтэй холбогдсон санал боловсруулж шийдвэрлүүлэх;

21.10.5.малчдыг төр засгаас дэмжлэг, туслалцаа авахад нь төлөөлөх, малчны хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

21.10.6.холбооны хөгжлийн түвшин, чадавхын үнэлгээ хийх, тодорхойлолт гаргах;

21.10.7.малчдад зориулсан үндэсний хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, худалдаа, олон улсын хэмжээний малчны соёлын чуулга уулзалтыг тогтмол зохион байгуулах;

21.10.8.малчин, малчны бүлэг, хэсэг, хоршооны шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, шилдэг туршлагыг дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;

21.10.9.малчдын бусад холбоодын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл өгөх.

21.10.10.хуульд заасан бусад чиг үүрэг.

21.11.Энэ хуулийн 21.4, 21.5, 21.7, 21.9-д заасан этгээд нь удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны дүрэмтэй байх ба дүрмийг нийт гишүүдийн саналаар батална.

21.12.Энэ хуулийн 21.9-д заасан нэгдсэн холбооны үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалт нь холбогдох хууль тогтоомжийн дагуу тодорхойлогдоно.

21.13.Мал аж ахуйн чиглэлийн бусад мэргэжлийн холбоо, хуулийн этгээд, мэргэжилтэн нь малчны өөрөө удирдах бүх шатны байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр холбогдох үйлчилгээг үзүүлнэ.

21.14.Төрийн байгууллага нь энэ хуулийн 21.6, 21.8, 21.10-д заасан хүрээнд төрийн зарим чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сум, аймгийн болон нэгдсэн холбоогоор гүйцэтгүүлж болно.

22 дугаар зүйл. Малчинд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

22.1.Санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан банк, үйлдвэр, малчны хамтын ажиллагаа, уялдааг сайжруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, малчны орон нутагтаа ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулна.

22.2.Арилжааны банкинд малчинд зориулсан нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй зээлийн болон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний шинэ нэр төрлийг нэмэгдүүлж малчин үйлдвэрлэлдээ чанарын өөрчлөлт гаргах, байгальд ээлтэй, тогтвортой үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

22.3.Энэ хуулийн 22.2-д заасан зээлийг дор дурдсан шаардлагыг хангасан малчинд олгоно.

22.4.1.малын тоо толгойн албан татвар төлөгч байх;

22.4.2.арилжааны банкинд “малчин данстай” байх;

22.4.3.эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг байх;

22.4.4.боловсруулах үйлдвэртэй түүхий эд бэлтгэн нийлүүлэх гэрээтэй байх;

22.4.5.малын тарга хүчийг холбогдох стандартад заасан зохих хэмжээнд хүргэсэн байх;

22.4.6.үржлийн хээлтүүлэгч малыг орон нутгийн мэргэжлийн байгууллага, мэргэжилтнээр үнэлүүлдэг байх;

22.4.7.малдаа туулга, тарилга, угаалгыг технологийн хугацаанд тогтмол хийлгэдэг, малын гоц халдварт болон бусад өвчний гаралт буурсан байх;

22.4.8.малын ашиг шимийн гарц, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд өмнөх 3 жилийн дундаж үзүүлэлтээс өсөлт гарсан байх.

22.5.Малчны нэн хөнгөлөлттэй зээлийн олгохдоо улс орны нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, тухайн жилийн байгаль, цаг уурын болон гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөлөл, түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээ зэргийг харгалзана.

22.6.Бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжиж, малчны дараах үйл ажиллагаанд нэн хөнгөлөлттэй зээл олгоно:

22.6.1.байгальд ээлтэй материалаар малын өвөлжөө, хаваржааны дулаан байр, хашаа хороо, саравч барих;

22.6.2.доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, малын тэжээл тариалах;

22.6.3.хөдөлмөр хөнгөвчлөх дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

22.6.4.хадлан, тэжээлийн техник, тоног төхөөрөмж худалдан авах;

22.6.5.эрсдэлийн үед цас цэвэрлэх, бэлчээр гаргах техник болон сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжтэй болох;

22.6.6.цас борооны ус тогтоож хөв, цөөрөм байгуулах;

22.6.7.тухайн бүс нутгийн малын үржлийн хөтөлбөрт заагдсан сайн чанарын үржлийн хээлтүүлэгч, хээлтэгч мал худалдан авах;

22.6.8.боловсруулах үйлдвэртэй түүхий эд бэлтгэн нийлүүлэх 3 жилийн тогтвортой гэрээ байгуулж, кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах;

22.6.9.түүхий эд бүтээгдэхүүнээ хадгалах эрүүл ахуйн шаардлага хангасан байр барих, түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ хийлгэх;

22.6.10.бусад.

22.7.Малчны дараах үйл ажиллагаанд хөнгөлөлттэй зээл олгоно:

22.7.1.шинээр гэр, орон байр барих, засварлах, шинэчлэх;

22.7.2.зөөврийн хашаа, өвс тэжээлийн агуулах шинээр барих, засварлах;

22.7.3.гүн өрөмдлөгийн болон гар худаг гаргах;

22.7.4.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийх, хөргөх тоног төхөөрөмжтэй болох;

22.7.5.малын сүү сааль, дайвар бүтээгдэхүүний ашиглалтыг нэмэгдүүлэх;

22.7.6.нийслэлээс хөдөөд албан ёсоор шилжин очиж малчнаар тасралтгүй 2 ба түүнээс дээш жил ажиллах.

22.8.Хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа, ашигласан эсэхэд зээлийн Хяналтын хороо хяналт тавина.

22.9.Малчны нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн санхүүжилт, хүүг Засгийн газраас тогтооно.

23 дугаар зүйл.Малчны хөрөнгө оруулалт, эдийн засгийн чадамжийг сайжруулах

23.1.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн одоогийн болон ирээдүйн хөгжлийг дэмжихэд зориулан сум бүрт Малчны хөгжлийн санг байгуулна.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

23.2.1.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс олгож байгаа мөнгөн урамшууллын нэг удаагийн орлогын хуваарилалт;

23.2.2.уул уурхайн салбарын орлогоос баялаг бүтээх салбарт хуваарилах хөрөнгөөс ногдох хувийн эх үүсвэр;

23.2.3.малчны малын тоо толгойн албан татварын орлогын төвлөрүүлэлтээс хуваарилах хөрөнгө;

23.2.4.малчны, малчны бүлгийн хувь нийлүүлэх хөрөнгө;

23.2.5.малчны өөрөө удирдах байгууллагаас хувь нийлүүлэх хөрөнгө;

23.2.6.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах үндэсний үйлдвэрийн хувь нийлүүлэх хөрөнгө;

23.2.7.олон улсын байгууллагын санхүүгийн буцалтгүй зээл, дэмжлэгийн эх үүсвэр;

23.2.8.хуулиар хориглоогүй бусад санхүүжилтийн дэмжлэгийн эх үүсвэр.

23.3.Энэ хуулийн 23.1-д заасан сангийн хөрөнгийн 30 хувийг бэлчээрийн мал ахуйд гэнэтийн гамшиг, эрсдэлийн үед ашиглахаар хуримтлуулна.

23.4.Сангийн бусад төвлөрүүлсэн хөрөнгийг жил бүр дор дурдсанаар хуваарилж, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчны хөгжилд дэмжлэг үзүүлэхэд зарцуулна:

23.4.1.тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд 30 хувь;

23.4.2.ногоон, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжихэд 30 хувь;

23.4.3.малчдыг хөгжүүлэх, чадавхжуулахад 10 хувь.

23.5.Энэ хуулийн 23.4.1, 23.4.2-д заасан зориулалтаар зарцуулах хөрөнгө нь бага хүүтэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл хэлбэртэй байна.

23.6.Малчны хөгжлийн сангийн удирдлага, зохион байгуулалтын жишиг дүрэм, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг сангийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

23.7.Өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа малчинд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу дэмжлэг үзүүлнэ.

23.8.Өргөтгөсөн үйлдвэрлэл эрхэлж байгаа малчинд энэ хуулийн 23.4-т болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.1-д заасны дагуу дэмжлэг үзүүлнэ.

23.9.Малчин өрхийг тогтмол орлого, хуримтлалтай болгох зорилгоор малчин, малчны бүлэг үндэсний үйлдвэрүүдтэй 3 жилийн бүтэгдэхүүн нийлүүлэлтийн тогтвортой гэрээ байгуулж, стандартын шаардлагын дагуу бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлийн дээд ханшаар бэлтгэн нийлүүлэх тогтолцоог хөгжүүлнэ.

23.10.Хариуцлагатай малчин баталгаажуулалтын гэрчилгээтэй малчны бүлэг, баг, сумын бэлтгэн нийлүүлсэн малын гаралтай, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортод гаргах гадаад худалдааны зах зээлийн тогтолцоог бий болгоно.

23.11.Энэ хуулийн 23.9, 23.10-д заасан тогтолцоог төр, хувийн хэвшил, малчны өөрөө удирдах байгууллагын хамтын гэрээ, үйл ажиллагаагаар хөгжүүлнэ.

23.12.Малчны өрхийн болон өргөтгөсөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрсдэлээс хамгаалах даатгалын харилцааг бие даасан хуулиар зохицуулна.

24 дүгээр зүйл.Малчны нийгмийн баталгаа, ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

24.1.Засгийн газраас дор дурдсан дэмжлэгийг үзүүлнэ:

24.1.1.малчны хөгжлийг дэмжих асуудлыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үе шат тус бүрт тусгах;

24.1.2.малчин өвлүүлэх үл хөдлөх хөрөнгөтэй болохыг дэмжиж, ипотекийн хөтөлбөрт хамруулах, зээлийн хөнгөлөлт үзүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх;

24.1.3.малчин өрхийн эргэлтийн хөрөнгийн үнэлгээ, малын бүртгэлийн системд суурилан банк санхүүгийн, зээлийн батлан даалтын болон даатгалын үйлчилгээг малчдад дарамтгүйгээр шуурхай үзүүлэх боломжийг бүрдүүлэх;

24.1.4.малчны хүүхэд бага ангид шинээр элсэн суралцахтай холбогдон малчин өрхөд үүсч байгаа хүндрэлийг багасгахад чиглэгдсэн арга хэмжээ авах;

24.1.5.малчны хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж, хэрэгжүүлэх;

24.1.6.малчин ахуй, өв соёлд суурилсан аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, эко бүтээгдэхүүн борлуулалтыг хөгжүүлэх;

24.1.7.малчдын ногоон үйлдвэрлэл эрхлэх ур чадварыг дээшлүүлэн, орлогыг нэмэгдүүлэх;

24.1.8.малчны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

24.1.9.малчныг байгалийн гамшиг, эрсдэлээс хамгаалах, мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

24.1.10.хөгжлийн бэрхшээлтэй малчинд тусламж, дэмжлэг үзүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

24.1.11.хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлнэ;

Тайлбар:Энэ заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

24.1.12.энэ хуулийн 24.1.2-д заасан нөхөн төлөлтийн журмыг Засгийн газар тогтооно;

24.1.12.хууль тогтоомжид заасан бусад.

24.2.Орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас дор дурдсан дэмжлэгийг үзүүлнэ:

24.2.1.орон нутгийг хөгжүүлэх арга хэмжээнд малчдын идэвх, оролцоог сайжруулж, малчдын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх;

24.2.2.мал аж ахуйг тогтвортой эрхлэхийг дэмжин хөгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг хамтын оролцоогоор бүрдүүлэх;

24.2.3.“Өнтэй өвөл, хавар” арга хэмжээг жил бүр тогтмол зохион байгуулах;

24.2.4.малчин өрх, мал бүхий этгээдийн өвс, хадлан, тэжээл бэлтгэх, дүгнэх шалгуурыг баталгаажуулж, болзолтой болгох;

24.2.5.малчдыг тогтмол орлого, хуримтлалтай болгох зорилгоор мал, мах бэлтгэн нийлүүлэх арга хэмжээг идэвхжүүлэх;

24.2.6.мал сүргийг экологийн даацад нийцүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг нягтруулах;

24.2.7.өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд малчныг хамруулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах ажлыг идэвхжүүлэх, ач холбогдлыг сурталчлах;

24.2.8.малчны гар хөдөлмөрийг хөнгөвчлөх боломж, нөхцөлийг сайжруулж, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх;

24.2.9.тухайлсан төсөл, дэд хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, малчдын орлого, ашгийг нэмэгдүүлэх;

24.2.10.малчин өрхийн хэрэглээ, шаардлагад нийцсэн явуулын худалдаа, соёл урлаг, ахуйн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

24.2.11.хууль тогтоомжид заасан бусад.

24.3.Малаа жилийн 4 улирлын туршид өөрсдөө маллаж байгаа, богд шилжүүлснээр 250 хүртэл толгой малтай, 16-40 хүртэлх насны малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулна.

24.4.Байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөлөлд өртсөн малчин өрхийг малжуулах асуудлыг орон нутгийн бодлогоор шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл.Алслагдсан бүс нутгийн болон хариуцлагатай малчинд төрөөс үзүүлэх дэмжлэг

25.1.Улаанбаатар хотоос 400 км-ээс дээш алслагдсан сумын малчин өрхөд бүсийн нэмэгдэл олгож, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ.

25.2.Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьшиж, мал маллах иргэдийг бизнес эхлүүлэхэд татварын болон зээлийн бодлогоор дэмжинэ.

25.3.Хариуцлагатай малчин баталгаажуулалтын гэрчилгээ бүхий малчны бүлэг, баг, сумыг жил бүр шалгаруулж, урамшуулж, дэмжлэг үзүүлнэ.

25.4.Алслагдсан бүс нутгийн малчны болон малын тооны мэдээлэл, малын тоо толгойн албан татвар төлсөн байдлын талаарх мэдээллийг аймгийн хөдөө аж ахуйн болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцан нэгтгэж, холбогдох мэдээллийн системээр дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

25.5.Хариуцлагатай малчин баталгаажуулалтын гэрчилгээ авсан малчны бүлэг, баг, сумын талаарх мэдээллийг стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан байгууллага нэгтгэж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

25.6.Алслагдсан бүс нутгийн болон хариуцлагатай малчин, малчны бүлэг, хоршоо, баг, суманд төрөөс дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

26 дугаар зүйл.Санхүүжилт

26.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

26.1.1.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

26.1.2.малын тоо толгойн албан татварын орлогыг төвлөрүүлэх сан;

26.1.3.орон нутгийг хөгжүүлэх сан;

26.1.4.сумын хоршооны сан;

26.1.5.олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж;

26.1.6.арилжааны банкны эх үүсвэр;

26.1.7.малчид, мал бүхий этгээдийн хөрөнгө оруулалт;

26.1.8.гадаад, дотоодын байгууллагын хөрөнгө оруулалт;

26.1.9.хуульд заасан бусад эх үүсвэр.

27 дугаар зүйл. Хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

27.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

27.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын баталсан журмын дагуу хийж, тайланг Засгийн газарт хүргүүлнэ.

27.3.Энэ хуулийн 27.1-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах, судалгаа, шинжилгээ хийх, малчны болон бусад хамаарал бүхий оролцогчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, санал зөвлөмжийг авах ажлыг аймаг, сумын хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох бүтцийн нэгж хариуцан гүйцэтгэнэ.

27.4.Хэрэгжилтийн тайланд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болох ба шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

28 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ